

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Мягмар гараг*

***Хуралдааны тэмдэглэлийн агуулга***

***Хуралдааны товч тэмдэглэл:*** 1-3

***Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:*** 4-22

---

<i>1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	4-17
<i>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	17-18
<i>3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай/</i>	18-21

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Ёс зүй, дэгийн байнгын хорооны  
10 дугаар сарын 22-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 53.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 04 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, мөн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын ахлах аудитор Ц.Батсүх, Ш.Наран, аудитор Ж.Мөнхбилгүүн, Г.Оюунтөгөлдөр, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Ю.Энхтуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн газрын ахлах мэргэжилтэн Т.Анхбаяр, мэргэжилтэн Ч.Мөнхшүр, Б.Энхжин, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, мөн газрын ахлах шинжээч З.Анар, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн хэлтсийн ахлах шинжээч Э.Цолмон, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн П.Энхманлай, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн хэлтсийн мэргэжилтэн О.Гантулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Р.Хангал, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Хэрлэн, Г.Очирбат, Д.Энхтуяа нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, мөн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Баярбаатар:** “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 16 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийн дагуу явуулсан шалгалтын дүнг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн тавьсан асуултад Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар “Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Баярбаатар:** “Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 5  
Бүгд: 13

61.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 16 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 42 минут үргэлжилж, ирвэл зохих 13 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр 16 цаг 46 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
15 цаг 04 минут.

### ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Баярбаатар:** Улаанбаатар хотод цаг 15 цаг 04 минут болж байна. Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан 53,8 хувьтайгаар ирц хүрсэн тул хуралдааныг нээснийг мэдэгдье. Аюушийн Ариунзаяа гишүүн 14 цаг 49 минут, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн 14 цаг 57 минут, Баярмагнайн Баярбаатар гишүүн 14 цаг 52 минут, Даваасамбуу овогтой Ганмаа гишүүн 15 цаг 01 минут, Чулуунбилэг овогтой Лодойсамбуу гишүүн 15 цаг 03 минут, Дүгэрийн Рэгдэл гишүүн 15 цаг 00 минут, Бадарчийн Хэрлэн гишүүн 15 цаг 00 минут гэсэн цагийн бүртгэлээр ирц бүрдлээ. Дуламын Бум-Очир гишүүн нэг арга хэмжээ давхацсан учраас албан ёсоор чөлөө хүссэн. Тэгэхдээ хоцроод бол хуралдаандаа орж ирэхийг бол мэдэгдсэн.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулна. 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, ЗГ-ын 2024 оны 8 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. 2.Байнгын хорооны тогтоолын төсөл Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал

боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай. 3.Байнгын хорооны тогтоолын төсөл. Ийм 3 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? 3 дахь асуудал нь. Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой санал байхгүй учраас хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Ажлын хэсэг эхний асуудал 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар хийнэ. Ажлын хэсгийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан, Монгол Улсын ерөнхий аудитор Загджав өвчний чөлөө авсан учраас орлогч, Л.Цэдэвсүрэн ТАЗ-ийн дарга, Ёс зүйн хорооны гишүүн, Ц.Амартөгс Ёс зүйн хорооны дарга, ТАЗ-ийн гишүүн, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Ж.Ганбат Сангийн яамны ТНБД, С.Батболд ЗТЯ-ны ТНБД, Т.Даваадалай НЗД-ын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан I дүгээр орлогч, О.Амартүвшин Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх, Н.Ганбаатар Ёс зүйн хорооны ажлын албаны дарга, Ц.Наранчимэг Санхүү нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын

захирал, тэргүүлэх аудитор, М.Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, З.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Болор-Эрдэнэ ЗТЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Ч.Сугармаа ЗТЯ-ны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга, Ц.Баярбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын газрын дарга, Б.Энхжин НЗДТГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Ц.Ариунсанаа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Э.Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Т.Сумъяа ЗТЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Л.Мөнхцацрал Санхүү нийцлийн аудитын газрын аудитын менежер, Ю.Энхтуяа Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын аудитын менежер, Ц.Батсүх Санхүү нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ш.Наран Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ж.Мөнхбилгүүн Санхүү нийцлийн аудитын газрын аудитор, Г.Оюунтөгөлдөр Санхүү нийцлийн аудитын газрын аудитор, Ж.Төгөлдөр Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн,

Т.Анхбаяр Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн, П.Энхманлай Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Р.Хангал Сангийн яамны Төсөв, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, О.Гантулга Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн, Б.Энхжин Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Ч.Мөнхшүүр Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Э.Цолмон Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах шинжээч, З.Анар Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын ахлах шинжээч гэсэн ажлын хэсэг.

Би чинь бараг 50-иад хүний нэр уничихлаа. Энэ чинь хэдэн хүн сууж байна вэ одоо? Энэ саяын нэр уншсан улсууд хаана байгаа юм бэ? Түүн дээр байгаа юу, тэр нь аль танхимд хуралдаж байгаа юм бэ? Хүлээх үү, энэ чинь юугаа яах учраас. Ажлын хэсэг ороод ирсэн. Эхний асуудал хэлэлцэнэ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулсан байгаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Болдын Жавхлан сайдыг урьж байна.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн өдрийн мэндийг эрье. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 25 оны төсвийн тухай хуулийн төслийг 24 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Ёс зүй, дэгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна. Монгол Улсын ЗГ-ын



бүрэн эрхийн хугацаанд Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих татвар, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформ, эдийн засгийн суурийг тэлж хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Ирэх 2025 он нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас ирэх оны төсвийг бүсчилсэн хөгжилд шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, орон нутгийн бие даан хөгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс онцлогтой юм.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33,9 их наяд төгрөг, суурь зарлага 32 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,9 их наяд төгрөгийн ашигтай байхаар байна. Иймд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баярбаатар:** Жавхлан сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ядамын Самбууням

танилцуулна. Хэддүгээр микрофон байна вэ? 6 дугаар микрофоныг өгөөрэй.

**Я.Самбууням:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ёс зүй, дэгийн Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн, аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, ЗГ-т хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн болно. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлогыг 33 их наяд 864,7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35,6 хувь, нийт зарлагыг 35 их наяд 795,2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37,7 хувь, төсвийн суурь тэнцлийг 1 их наяд 909,5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1 их наяд 930,5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ. ЗГ-аас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн

захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ.

Үүнд Улсын Их Хурлын даргын төсвийг 191,1 тэрбум, 191 тэрбум төгрөг, ТАЗ-ийн даргын төсвийн орлогыг төвлөрүүлэх орлогыг 0,2 тэрбум, урсгал, нийт зарлагыг 21,9 тэрбум, АТГ-ын нийт зарлагыг 58,2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөжээ. Тус байнгын хороонд хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага ба зээлийн дүнг 2024 оны тодотгосон төсвөөс 73,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын даргын төсвийн багцын урсгал зардлын төсвийг 55,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 175,4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 23,6 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ хураамжийн зардлыг 4,8 тэрбум төгрөг, бараа, ажил, үйлчилгээний бусад зардлыг 14,9 тэрбум төгрөг бусад урсгал шилжүүлгийн зардлыг 1,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна. Хөрөнгө оруулалтын төсвийг 2 төсөл, арга хэмжээнд нийт 15,6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

2. ТАЗ-ийн даргын төсвийн багцын урсгал зардлын төсвийг 14,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 21,9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 2,5 тэрбум, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,1 тэрбум төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ хураамжийн зардлыг 6,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

3. АТГ-ын даргын төсвийн багцын урсгал зардлыг 10,1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 55,5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь мөн цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 8,8 тэрбум, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн

мөнгөн тэтгэмжийн зардлыг 1,4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. АТГ-ын даргын багцын хөрөнгө оруулалтын төсвийн төсөвт 2 төсөл, арга хэмжээнд 2,7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа. Танилцуулж дууслаа.

**Б.Баярбаатар:** Самбууням даргад баярлалаа. Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн талаарх товч танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно. Ингээд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчаас асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Очирбат гишүүнээр, Хэрлэн гишүүн, Хэрлэн гишүүнээр асуулт тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууна.

**А.Ариунзаяа:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ТАЗ-ийн даргын багцын 25 оны төсвийн товч танилцуулгад нийт зарлага, цэвэр зээлийн дүн, ер нь төсөв 3 дахин нэмэгдсэн харагдаад байх юм. Тэгээд энэ төсөв яагаад нэмэгдэв гэдэг ерөнхий тайлбаруудыг бас харсан. Энийг бас нэг дэлгэрэнгүй дахиад нэг тайлбарлаж болох уу? Урсгал шилжүүлэг 71 хувь өссөн нь тэтгэвэрт гарах хүний тоо нэмэгдсэнтэй холбоотой гэж бас тайлбар ирүүлсэн байна. Ер нь тэтгэврийн насны төрийн албан хаагчдыг ажлаас нь гаргах, шахах ер нь байгууллагууд тэтгэврийн нас ойртсон



тэтгэврээ тогтоолгох гэж байгаа хүмүүсийг бас ажлаас нь халах явдлууд цөөнгүй гардаг л даа. Тэгээд энэ дээр төрийн бодлого бас хамгаалах талд бол нэлээд гарсан.

Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогчийн санаачилгаар тэтгэвэрт нь гаргаж шахаж болохгүй гэдэг ийм заалт Хөдөлмөрийн тухай хуулиар орсон. Ахмад настны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 24 онд жишигээр 4 сард өөрчлөлт орсон нь ААНБ-ын өмчийн хэлбэр үл хамаарч ААН байгууллагууд 50-аас дээш ажилтантай бол 2 хувьд нь тэтгэврийн ахмад настныг ажиллуулна гэсэн ийм хуулийг бас баталсан байгаа. Мэдээж тухайн ААН байгууллагуудад бас ямар давуу тал үүсэх вэ гэхээр тэтгэврийн шимтгэл ажил олгогч 8,5 хувийг төлөхгүй байх ийм давуу талтай. Ийм учраас аль болох тэтгэврийн хүмүүсийг бас ажиллах боломжтой үед нь ажиллуулж байх ийм хэрэгцээ шаардлага байгаа юм. Тэгэхээр ТАЗ-өөс яг энэ тэтгэврийн тэтгэвэртээ гарсан төрийн албанд ажиллаж байгаа хэр олон хүмүүс байгаа вэ? Танайх бас өөрийнхөө байгууллагадаа энэ гарч байгаа зардлыг бас бууруулах боломжтой юм шиг л харагдаад байна л даа нэг талдаа. Тэгэхээр энэ ахмадуудын талаар нэг талдаа төрийн алба болон яг ТАЗ дотроо байгаа асуудал мөн түүнчлэн энэ зардал яагаад бараг 3 дахин нэмэгдэв гэдгийг нэг талдаа асуух гэсэн юм.

2 дахь асуулт нь болохоор аудитын байгууллагаас энэ Төрийн хэмнэлтийн тухай хууль 22 онд анх батлагдаж байсан. Яг ковид цар тахлын дараа батлагдах яг тэр үедээ бол үнэхээрийн цаг хугацаандаа хэрэгцээндээ нийцэж байсан ийм сайн хууль болсон гэж би төдийгүй олон улсад ч гэсэн үнэлэгдээд явж байгаа. Цар тахлын цаг үе эдийн засгийн сэргэлтийн үеэр өөрчлөгдөж, эдийн засгийн сэргэлт нэг талдаа явагдсан. Тэгэхээр төр өөрөө алаг цоог хуулиа хэрэгжүүлж болохгүй учраас энэ хуулийн хэрэгжилт ямар байгаа вэ?

**Б.Баярбаатар:** 3 номерын микрофон, Цэдэвсүрэн дарга эхлээд хариулна.

**Л.Цэдэвсүрэн:** Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. ТАЗ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв бол 2 байгууллагын төсөв байгаа гэдгийг гишүүддээ бас хэлье гэж бодож байна. ТАЗ-ийн ажлын албаны төсөв, Ёс зүйн хорооны ажлын албаны төсөв гэсэн ийм биеэ даасан 2 хуулийн этгээдийн төсөв нийлээд 21,8 тэрбум болж байгаа юм. Ёс зүйн хорооны төсөв яагаад ТАЗ-ийн даргын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад ороод ирэв гэхээр 2024 оны 2 сараас эхлээд Ёс зүйн хороо яг албан ёсоор 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, үйл ажиллагаагаа бол явуулж эхэлсэн. 24 орон тоотой ажиллах ёстой. Тэгээд бид нар эхнээсээ хүмүүсээ аваад ажилд нь оруулаад явж байна. Орон тоогоо энэ ондоо багтаагаад бол дуусгаж авна. Тэгэхээр энэ байгууллагын маань 25 оны төсөв бүхэлдээ нэмэгдэж орж ирсэн байгааг хэлэх гэсэн юм.

Ёс зүйн хороо өөрөө Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Их Хурлаас баталсан үндэсний хөтөлбөрийн хүрээнд 11 чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх төсвийг хууль, хуульдаа улсын төсвөөс зарцуулна гээд ингээд хуульчилчихсан байгаа. Энэ нь бол шалтгаан болж байна гэсэн үг. Цалин, тэтгэвэр, цалинтай холбоотой, урсгал зардалтай холбоотой асуудлууд бол мэдээж ТАЗ 56 орон тоотой, Ёс зүйн хороо 24, ингээд нийлбэр дүнгээрээ энэ хүмүүсийн цалин хөлс, үйл ажиллагааны зардал бол энд бүгд орсон байгаа гэдгийг бас гишүүнд хэлэх гэсэн юм.

2-т нь ТАЗ-өөс 2025 онд 3 хүн тэтгэвэртээ гаръя гэдэг саналаа энэ ондоо өгөөд, бид нар 25 онд тэр хүмүүсийг тэтгэвэрт гарахад өгдөг 36 сарынх нь дундаж нэмэгдлийг

тэтгэмжийг энэ төсөвтөө тусгачихсан байгаа. Ер нь зүгээр Монгол Улсын төрийн албанд тэтгэвэрт гарсан хүмүүсийг буцааж ажиллуулах тодорхой ажил эрхлэх боломжийг нь бол аль болохоор ТАЗ дэмжиж байгаа. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 6669 иргэн тэтгэврээ тогтоолгогчлоод төрийн албанд ажиллаж байна. Үүний 6300 нь төрийн үйлчилгээний албанд. Яагаад төрийн үйлчилгээний албанд тэтгэвэр тогтоолгосон хүмүүс маань илүүтэй ажиллаад байна вэ гэхээр 22 онд батлагдсан Хөдөлмөрийн хуулиар энэ маань нээлттэй болсон. Төрийн үйлчилгээнд ажиллах хүмүүс тэтгэврээ тогтоолгогчлоод буцаад төрийн албанд ажиллах эрх нь нээгдсэн.

2 дахь нь цэргийн тэтгэвэр тогтоолгосон залуу хүмүүс, ялангуяа идэр насныхан бол төрийн албаны шалгалт өгөөд төрийн байгууллагуудад бас хөдөлмөр эрхлэлтийг нь бол манай байгууллага бас нэлээн дэмжиж байгаа. Тэгэхээр аль болохоор нөгөө нэг ч тэтгэвэртээ гар, одоо тэтгэврийн нас чинь боллоо гэж шахахаасаа илүүтэй тэр хүний хөдөлмөрлөх нас, бүх бие физиологи болон бүх зүйл нь шаардлага хангаж байгаа тохиолдолд төрийн үйлчилгээний албанд ажиллах боломжийг нь бол хангах нь зүйтэй л гэж үзэж байгаа. Энэ тэгэхдээ саяын миний хэлдэг 6371 хүнтэй холбоотой асуудал манай байгууллагын 25 оны төсөвт бол тусаагүй. Би Ариунзаяа гишүүнд зүгээр нэмэлт асуусан учраас хариулт өгч байгаа юм. Тэр 113,6 сая гэдэг нь манай байгууллагын 3 иргэний тэтгэвэрт гарахад өгөх 36 сарын дундаж мөнгө юм байгаа юм.

**Б.Баярбаатар:** Самбууням дарга 6 номерын микрофон.

**Я.Самбууням:** Үндэсний аудитын газар Самбууням байна. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсан. Төрийн хэмнэлтийн тухай хуульд энэ хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт

тавьж ажиллах чиг үүргийг төрийн аудитын байгууллага болон Сангийн яаманд үүрэг болгосон байдаг. Бид жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг төсөв захирагч бүр дээр хянаж үздэг байгаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг 2022 онд 61,6 тэрбум төгрөгийн зөрчилд 1979 зөрчлийг илрүүлсэн. Энд холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийг өгсөн байгаа. 2023 онд 56,8 тэрбум төгрөгийн 1058 зөрчлийг илрүүлсэн байгаа. Энд мөн бас акт, албан шаардлага зөвлөмжийг өгч ажилласан. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийтдээ 6814 байгууллагыг хамруулж, Төрийн хэмнэлтийн тухай.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 6 номерын микрофон гүйцээгээд хариулчихъя.

**Я.Самбууням:** Мөн хянасан байгаа. Үүгээр мөн 56, нийтдээ зөрчлийг давтан гаргахгүй байх 19,8 тэрбум төгрөгийн 408 зөвлөмжийг өгсөн. 36,1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 383 албан шаардлагыг өгсөн байгаа. Мөн 0,9 тэрбум төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлэх 271 төлбөрийн актыг тогтоосон. Мөн бид 2023 оны ЗГ-ын нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан зарим арга хэмжээний холбогдох дүрэм журмыг боловсруулаагүй, байгууллагуудаас татан төвлөрүүлсэн, шилжүүлсэн автомашины бүртгэл ашиглалт улсын дугаарын шилжилт хөдөлгөөн, худалдан авалтын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байгаа. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Ариунзаяа гишүүн тодруулах уу? Ариунзаяа гишүүн тодруулна 1 минут.

**А.Ариунзаяа:** Зөрчил давтагдаж байгаа байгууллагуудад та хэд ямар арга

хэмжээ авч байгаа вэ? Одоо өргөн барьсан байгаа энэ 25 оны төсөв Хэмнэлтийн тухай хуульд хэр зэрэг нийцсэн байгаа зэрэгт та бүхэн хяналт тавьж чадсан уу?

Дээрээс нь энэ зөрчил гараад байгаа нь өөрөө хууль маань өөрөө тухайн цаг үеэсээ буюу ковид цар тахлын дараах үе мөн одоо эдийн засгийн сэргэлтийн тодорхой хэмжээнд сэргэж байгаа үе хоорондоо ер нь нийцэхгүй байгаа юм биш биз дээ? Хэмнэлтийн тухай хуулийг ер нь өөрчлөх шаардлагатай гэж аудит үзэж байгаа юу эсхүл болж байна гэж үзэж байна уу?

**Б.Баярбаатар:** 6 номерын микрофон Самбууням дарга.

**Я.Самбууням:** Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Төрийн хэмнэлтийн тухай хууль ковид цар тахлын дараах эдийн засгийн хүндрэлийг даван туулахад зориулагдаж гарсан. Тэгээд төрийн хэмнэлтийн тухай хуульд бол тухайн үеүдэд нь нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулаад явсан байдаг. Бид Төрийн хэмнэлтийн тухай хууль тодорхой хэмжээнд энэ төсвийн буруу зарцуулалтуудыг хэмнэхэд зориулагдсан учраас энэ хуулийг цаашид нь хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж дүгнэж байгаа. 2025 оны төсөв дээр нийтдээ 93,1 тэрбум төгрөг нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй байгаа энэ зардлыг бууруулж, хянахаар дүгнэлтийг гаргаж, Сангийн яам бол энэ дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлээд, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудад заасан бичиг хэргийн зардал, ном хэвлэлийн зардал, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, шуудан холбоо, интернэтийн зардал, эд хогшил, урсгал засварын зардал, норматив зардал гэдгээс 93,1 тэрбум төгрөгийг.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Дахиад тодруулах уу, 1 минут тодруулчихъя.

**А.Ариунзаяа:** 93,1 тэрбум төгрөг зөрчилтэй байна гэдэг санал гаргасныг зөрчлийг арилгаагүй байгаа юм байна гэж ойлголоо. Мөн үү? Одоо ажлын хэсгийн хэлэлцүүлгийн явцад энэ зөрчлийг арилгах ёстой юм байна гэж ойлгож, төсөвт 93 тэрбумын орон зай эргэж гарч ирэх ёстой юм байна гэсэн ойлголтыг авлаа. Мөн үү, үгүй юү? Улсын Их Хурал өөрөө хууль зөрчсөн хууль тогтоомжийг баталж болохгүй гэсэн ийм бодолтой би байдаг. Ийм учраас энэ дээр бас аль болох зөрчлийг арилгаж төсвөө батлах нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна. Энийг тодруулж өгнө үү, би зөв ойлгож уу, буруу ойлгож уу?

**Б.Баярбаатар:** Самбууням дарга 6 номер.

**Я.Самбууням:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчөөд илүү төлөвлөчихсөн байсан төсвийг 93,1 тэрбум төгрөгөөр хасаад, 2024 оны төсвийн төслийн Улсын Их Хуралд өргөн барьсан төсөл дээр оруулчихсан байгаа. Тэгэхээр зэрэг энэ хасагдчихсан байгаа зардал шүү. Тийм баярлалаа.

**Б.Баярбаатар:** Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууна.

**Х.Баасанжаргал:** Энэ төсвийн танилцуулгын яг энэ ёс зүйн хорооны хэсэгтэй холбоотой асуултыг асуугаадахъя. 2 байгууллагын төсөв нэг Албаны зөвлөлийн даргын багцад байгаа гэж сая тайлбарлалаа. Тэгэхдээ өсөлтийн хувиудыг нь ингээд харахаар нэлээн өндөр хувиуд байна л даа. Бараа, үйлчилгээний бусад зардал 1780 хувь гэж ойлгох гээд байна. Эд хогшлын зардал 800 хувь, томилолт, зочны зардал 998 хувь бусдаар, гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ 410 хувиар өссөн гэж гараад байна. Тэгэхээр сая зүгээр яах вэ зүгээр 24 хүний орон тоо нэмэгдэж байгаа гэж би бол ойлгож байна зөв үү Ёс зүйн хорооных. Тэгээд доод талын яг хэсэг дээр энэ Ёс зүйн хорооны үндсэн үйл ажиллагааны зардлыг тусгасантай холбоотой гээд 2,9 тэрбум

төгрөг буюу энэ 2,9 тэрбумыг Ёс зүйн хорооны 24 хүний бүрэлдэхүүнтэй энэ ажлын албаны зардал гэж нийтэд нь гэж ойлгох уу? Ер нь энэ өсөлтийн хувиудыг бас нэг нэлээн тодорхой хэлж өгөөч. Ялангуяа тэр бараа, үйлчилгээний бусад зардал гээд энэ өндөр хувьтай байгаа анхаарал татаад байгаа энэ 4 хувь дээр тайлбар өгөөч?

**Б.Баярбаатар:** Цэдэвсүрэн дарга, 3 номерын микрофон.

**Л.Цэдэвсүрэн:** 2024 оны төсөв дээр ТАЗ-ийн болон Ёс зүйн хорооны төсөв нь нийт 7 тэрбум. Ёс зүйн хороог түрүүн би бас гишүүддээ хэлсэн. Манай Ёс зүйн хороо бол 2024 оны 2 сараас яг албан ёсоор үйл ажиллагаа маань ингээд жигдрээд явсан. Тэгэхээр ТАЗ-ийн төсвөөсөө бид нар Ёс зүйн хороо руугаа бас төсвөө тасалж өгөөд, ингээд үйл ажиллагаанууд маань явж байгаа гэсэн үг л дээ. Тодотголоор бас тодорхой хэмжээний төсвүүдийг бол нэмж өгсөн. Энэ нь яасан гэхээр ТАЗ Ёс зүйн хорооны гишүүд болон Ёс зүйн хорооны даргын албан тушаалын ангилал тэнд ажиллаж байгаа албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл тодорхой биш байсныг 24 оны сая 5, 6 сард Их Хурлын тогтоол шийдвэрээр яг албан ёсны болгож өгөөд, энэ байгууллагын маань өөрийнх нь урсгал болон гүйцэтгэлтэй холбоотой бүх төсвүүд яг ингээд Төсвийн хуулийн дагуу зөв явагдаад эхэлж байгаа юм.

Хэт их нэмэгдсэн юм шиг харагдаж байгаа нь ТАЗ-ийн болон Ёс зүйн хорооны ажлын албаныхны цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудлуудыг бол ЗГ бас хэлэлцэж үзээд, тодорхой хэмжээний нэмэлтүүдийг бол хийж өгсөн байгаа 1 дэх нь.

2 дахь нь ер нь энэ ТАЗ-ийн өөрийнх нь төсөв, төсвийн нийт хэмжээнийх нь 68-аас 70 хувь нь ихэвчлэн цалин хөлс, нийгмийн даатгалд зарцуулагдаад явж байсан юм байна лээ. Тэгээд энийгээ бид нар залруулахын тулд бас урсгал зардал

дээрээ яг энэ төсвийн үйл ажиллагааны зардал дээрээ тодорхой төсвүүдийг оруулж өгөхгүй бол өнгөрсөн 23, 24 онд ч гэсэн ТАЗ-ийн зарим үйл ажиллагаанууд Ёс зүйн хорооны үйл ажиллагаанууд ихэвчлэн гуйлгын гээд хэлчихвэл арай муухай болчих байх. Тийм шинж чанартай явж байсан зүйлийг бол Сангийн яам бас нэлээн сайн судалсан, дэмжсэн. ЗГ бас дэмжсэн. Тэгээд нөгөө өсөлт гэдэг нь өмнө нь байхгүй байсан төсвүүдийг бид нар яг хуулийн дагуу ТАЗ-ийн хэрэгжүүлэх ёстой 11 чиг үүргийг яг бодит байдлаар нь бүрэн чанартай хэрэгжүүлж, Ёс зүйн хорооны хэрэгжүүлэх ёстой 11 чиг үүргийг хуулийн дагуу яг бодит байдлаар нь хэрэгжүүлж гэдэг үүднээс төсвийг яг бодитойгоор төлөвлөж оруулж ирэхэд д бол яах аргагүй л жоохон өсөлтүүд бол гарсан. Гишүүний асуултад нэмж хариулъя. Ёс зүйн хорооны маань төсөв бол энэ оны төсөв маань 1,1 тэрбум байсныг бид нар 3 тэрбум болгож нэмсэн байгаа.

**Б.Баярбаатар:** Асуулт, хариулт хангалттай юу Баасанжаргал гишүүн? 1 минут тодруулга.

**Х.Баасанжаргал:** Энэ цалингийн өсөлтүүд бол энэ тусдаа байгаад байгаа байхгүй юу 52,4 гээд, ингээд нийгмийн даатгалынх 48 гээд, энийг бол ойлгож байна. Тэрнээс гадна яг энэ нэг өндөр нэг хувиуд байгаад байна шүү дээ. Томлолт, зочны зардал гээд. Эд нар дээр яг ийм тусгайлан тайлбар байна уу? Нөгөө шинэ байгуулагдаж байгаа бүтэц учраас юу гэдэг юм тийм тайлбар байна уу л гэж асуугаад байгаа гэсэн үг. Цалин хөлснөөс өөр, бусад тэр 4 зардлыг асуугаад байгаа байхгүй юу.

**Б.Баярбаатар:** 3 номерын микрофон Цэдэвсүрэн дарга.

**Л.Цэдэвсүрэн:** ТАЗ-ийн хамгийн гол чиг үүрэг бол Улсын Их Хурал дахь төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой. Өнгөрсөн хугацаанд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад



ТАЗ яг хяналтын чиг үүргээр бол 5 тийм дэд чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг. Мааш их хөдөө орон нутагт томилолтоор явах шаардлагатай. Өнгөрсөн хугацаанд төрд учруулсан хохирол гээд та бүхэн маань бас мэдэж байгаа байх. Буруутай албан тушаалтны төрд учруулсан хохирлыг бид нар шүүхийн байгууллагад хандаж буцааж төлүүлж, энийгээ Сангийн яамны Төрийн сангийн дансанд жил болгон төвлөрүүлдэг юм. Энийг энэ 25 оноос эхлээд түрүүний танилцуулдаг 0,2 тэрбум буюу 200 саяыг бид нар орлогод төвлөрүүлж гэдэг ийм зарчим явж байгаа.

Томилолтын зардал яагаад ингэж нэмэгдсэн юм бэ гэхээр өмнө нь бол бараг байдаггүй байсан. Бид нар энэ төрд учруулсан хохирлынхоо 10 хувийг буцаагаад Сангийн яамтайгаа ярьж байгаад аваад, тэрийгээ томилолт хэлбэрээр ашигладаг байсан.

**Б.Баярбаатар:** 3 номер дээр гүйцээгээд хариулчих.

**Л.Цэдэвсүрэн:** Хөдөө орон нутагт томилолтоор ажиллах Ёс зүйн хороо, ТАЗ аль аль нь томилолтын зардал мааш бага байсан бараг байхгүй. Тэгэхээр бид нарт бол томилолтоор хөдөө орон нутагт ажиллах, хяналт шалгалт хийх, сургалт соён гэгээрлийн ажил зохион байгуулах гээд мааш олон хэрэгцээнүүд байгаа. Энэ нь бол хуульчлагдчихсан. Энийг хэрэгжүүлэхийн тулд бид нар 25 онд бас төлөвлөгөө гаргаад, улсын хэмжээний хяналт шалгалт, хөдөө орон нутгийн томилолт болон гадаад зочны асуудлыг бас тавьсан байгаа. Яагаад гадаад зочин дээр та нар мөнгө төлүүлчэв гэхээр Ёс зүйн хороо болон ТАЗ-ийн гадаад харилцааны асуудлыг 24 оноос эхлээд нэлээн эрчимтэй хөгжүүлж эхэлж байна. Бид нар зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулаад байхаасаа илүүтэй гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, энэ чиглэлээрээ бас 25 онд хэд хэдэн бид нар өөрсдөө гадаадад томилолтоор явахаасаа илүүтэй

гадаадаас зочин хүлээж авч, хамтын ажиллагааны өргөжүүлэлтийг хийнэ гэдэг төлөвлөлтийг бас хийсэн байгаа.

**Б.Баярбаатар:** Баярлалаа. Техникийнхэнд хэлэхэд Энхтуяа гишүүний нэрийг нэмээд оруулчаарай. Асуулт асуух гишүүдийн нэрс дээр Доржзодовын Энхтуяа. Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууна.

**Б.Хэрлэн:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Надад 2 асуулт байна. Нэгдүгээрх нь болоод ирэхээр ер нь бол 2013 оноос эхлэн төрийн бүх байгууллагууд үр дүнд суурилсан менежмент буюу төсвөөр хөтөлбөрөөр төсөвлөх энэ арга зүйг хэрэгжүүлээд явж байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн зарцуулж байгаа нэг төгрөг ч гэсэн тодорхой нэг үр дүнд чиглэсэн, тодорхой нэг хөтөлбөр төсөвт хөтөлбөрт хамаарсан байх ёстой гэсэн энэ санаагаар бол төсвийг хийгээд явж байгаа. Тэгэхээр энэ үр дүнд чиглэсэн энэ менежмент чинь бол ердөөсөө л тухайн байгууллагын чиг үүрэг, тэгээд бүтэц зохион байгуулалт, тэгээд дээр нь хөтөлбөр төлөвлөгөө, төсөв мөнгө гээд л ингээд бүх юмтай нь уялдаж байдаг ийм цогц ийм үзэл баримтлалыг хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр миний асуулт яг юунд чиглээд байна вэ гэхээр өнөөдөр энэ ТАЗ-ийн 25 оны төсөв орж ирэхэд энд хөтөлбөрүүдийг 10 хөтөлбөрөөр төсөвлөж, төлөвлөсөн байна л даа. Төлөвлөгөөгөө гаргаж ирсэн байна төсвийнхөө төлөвлөгөөг. Тэгэхээр энэ дээр яг Төрийн албаны тухай хуульд тусгагдсан тэр чиг үүргүүдийн дагуу энэ хөтөлбөрүүдээ гаргаж ирэв үү? Ер нь өнөөдөр яг энэ хамгийн 1 дүгээрт л тухайлах юм байна л даа. Тухайлбал Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийг эрчимжүүлнэ гээд ингээд ороод ирсэн байна. Тэгэхээр ТАЗ чинь өөрөө яг нэг хууль санаачлах ийм эрхтэй байгууллага мөн үү, үгүй юү? Танай байгууллагын бүрэн эрхэд энэ туссан уу, үгүй юү ч гэдэг юм уу. Тэгэхээр яг энэ



хэрэгжүүлж байгаа энэ хөтөлбөрөөр төсөвлөх гэсэн энэ зарчим санаагаар ажиллахад өнөөдөр бид нар яг чиг үүрэгтэйгээ хийж байгаа ажлаа, төсөв мөнгөө, энэ бүх юмаа уях тал дээр ер нь бид нарт ямар асуудал гарч байна вэ? Энийгээ ер нь тулгаж харсан уу гэж би 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт нь энэ дээр ингээд яг ингээд төсвийг төсөв мөнгийг харж байхад бол энэ байгууллагын ТАЗ-ийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын нийт зардлын хэмжээ нь болоод ирэхээр 7 тэрбум 211,9 сая төгрөг, тэгээд бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж нь 8 тэрбум 397,7 сая гээд тэгж байна л даа. Тэгэхээр энэ 2 дахь асуулт маань яг юу хэлэх гээд байна вэ гэхээр чинь танай ТАЗ-ийн орон тоог цаашаа нэмэх хэрэгтэй гэсэн үг үү? Өөрөөр хэлбэл нийт ажилтан, албан хаагчдынхаа цалингийн сангаас бүүр давсан тийм их өртөг зардлаар бусдаар ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэе гэж байна шүү дээ. Тэгэхээр ер нь ТАЗ-ийг цаашид нь бэхжүүлэе гэх юм бол өнөөдөр 80 хүний орон тоотой ажиллаж байгаа бол магадгүй 160 хүний орон тоотой ажиллах зайлшгүй шаардлага байна гэсэн ийм утга эндээс харагдаж байна уу? Энийг тайлбарлаад өгөхгүй юу?

**Б.Баярбаатар:** Цэдэвсүрэн дарга 3 номер.

**Л.Цэдэвсүрэн:** Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 25 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон үзүүлэлт дээр ТАЗ-ийн чиг үүрэгтэй холбоотой болон Ёс зүйн хороотой холбоотой ингээд хөтөлбөрүүд тавигдчихсан байгаа. Энэ хөтөлбөрүүд бүгдээрээ манай 2 байгууллагын Төрийн албаны хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн үндэсний хөтөлбөрт байгаа чиг үүргүүд бүгд шингээд орчихсон байгаа. ТАЗ-ийн хэрэгжүүлдэг 4 том чиг үүрэг байна л

даа. Эхнийх нь хяналт шалгалт, хяналт шалгалтын чиг үүрэг дотроо 4 бүлэгтэй. Дараачийнх нь сонгон шалгаруулалт, сонгон шалгаруулалт өөрөө дотроо 2 бүлэгтэй. 3 дахь гол чиг үүрэг нь бид нар Монгол Улсын нийт төрийн албан хаагчдын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлдөг. Энэ хөтөлөлт маань бол мэдээллийн систем дээр суурилж явагддаг. 4 дэх чиг үүрэг маань бол хүний нөөцийн аудит хийх, сургалт эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалтыг хангах гэсэн ийм хуулийн 11 чиг үүргээ базаад хэлбэл 4 гол чиг үүрэгтэй байгаа.

Тэгэхээр энэ чиг үүргүүд маань бол энэ саяын таны хэлсэн 13.1.1-ээс 1.9-д тусчихсан байгаа ажлууд маань бол бүгд ороод ирсэн. Энийг тусгахдаа Сангийн яамтайгаа юу гэж зөвлөсөн бэ гэхээр ЗГ-ын үйл ажиллагааны 24-өөс 28 оны хөтөлбөрт туссан үйл ажиллагааны агуулгуудыг бүхэлд нь шингээх нь зүйтэй гэж үзэж, энийг бас тусгасан байгаа. Мэдээж манайх бол хууль санаачлах эрхгүй. Тэгэхдээ Төрийн албаны хуулийг дагаж гарч байгаа 47 дүрэм журмын боловсруулалт болон хэрэгжилт баталгаажуулалт дээр манайх бол заавал оролцож байгаа. Дийлэнхийг нь манайх бас өөрсдөө баталж байгаа. Тэгэхээр энэ эрх зүйн шинэчлэл гэдэг маань хууль гэдгээсээ илүүтэй 19 оноос хойш энэ батлагдаад өнөөдрийг болтол мөрдөөд байгаа дүрэм журмуудын шинэчлэл дээр нэлээн акцент өгч энэ томъёоллыг хийсэн.

Ёс зүйн хорооны маань 4 гол хөтөлбөр бол бас л яг хуультайгаа холбогдсон, дүрэм журамтайгаа холбогдсон ийм чиг үүргүүд байгаа. Бусдаар гүйцэтгүүлэх гэдэг дээр бол 2 гол ажил явдаг. Энэ дээр бол энэ системийн хөгжүүлэлтүүд, системийг өнөөдөр бол хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо гэсэн том систем маань явж байна. Энэдээ бид нар ёс зүйн системийг нэмж байгаа. Дэд систем бий болгож байна. 2 дахь дэд систем нь сонгон шалгаруулалтын төстийн сангийн дэд

системийг хийгээд ер нь дуусаж байна. 3 дахь нь бол маргаан хянан шалгах болон төрд учирсан хохиролтой холбоотой дэд системүүдийг хийж байгаа. Эд нар маань бүгд нөгөө хөгжүүлэлт, энэтэй холбоотой бас дэд бүтцийн асуудлууд үүсэж байгаа учраас мөнгөн дүн ингээж өндөр тавигдсан мэтээр харагдахыг бол бас хүлээн зөвшөөрч байна. Тэгэхдээ энэний цаана дандаа төлөвлөчихсөн ажил, хуулиар хүлээсэн үүргүүд байгаа гэдгийг бас гишүүддээ хэлэх гэсэн юм.

**Б.Баярбаатар:** Хариулт болсон уу? Батсуурь сайд ирцдээ орчихвол манай ирц 100 хувь болчих гээд байдаг. Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууна.

**Ч.Лодойсамбуу:** Сайн байцгаана уу. Жавхлан сайд энэ юу руу орно тийм ээ Эдийн засгийн байнгын хороо руу. Эдийн засгийн байнгын хороон дээр асуултаа асуучихъя.

**Б.Баярбаатар:** Дараагийн гишүүн, Ганбатын Очирбат гишүүн асуулт асууна.

**Г.Очирбат:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд Байнгын хорооны нөгөө эрхлэх асуудлын хүрээнд ТАЗ-ийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага нь 2024 оны тодотгосон төсвөөс 14,3 тэрбум төгрөг буюу 89,6 хувиар өсжээ. Тэгээд манай ТАЗ-ийнхөн маань яг манай төрийн албан хаагч ингээд төсөв юу гэдэг юм та хэд дээр төсөв чинь ингээд өсөж байгаа яг төрийн албан хаагч нар ер нь хэрхэн байгаа вэ? Ялангуяа энэ залуучууд төрийн алба руу орох сонирхол хэр байгаа юм бэ? Яг төрийн албан хаагч нарын нөгөө хүний нөөцийн бүтэц тал дээр нь ямархуу байр байдалтай байгаа вэ? Их олон албан хаагч нар миний зүгээр мэдээлэл авч байгаагаар гадагшаа дотогшоо явж байна. Төрд ажиллах сонирхолгүй болж байна гэсэн ийм хандлага яваад байдаг. Бид дээрээс нь та хэдийн төсвийг ингээд 89 аравны бараг 90 хувиар ингээд нэмэх гээд сууж байдаг.

Тэгээд энэ дээр нэг хариулт авчихмаар байна.

2-т гэх юм бол ТАЗ-ийн төсвийн төсөлд эд хогшил, урсгал засварын зардал 1,2 тэрбум төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 3,1 тэрбум төгрөгийг тус тус тусгасан байна. Эдгээрийн товч задаргааны талаар хариуцсан хүн нь байвал хэлээд өгөөч. Яг ямар эд хогшилыг солих гээд байгаа юм 1,2 тэрбумаар, 3,1 тэрбумаар яг юу хийх гээд байгаа юм гээд? Үндсэн 2 асуултад авчихъя.

**Б.Баярбаатар:** 3 номерын микрофон Цэдэвсүрэн.

**Л.Цэдэвсүрэн:** Гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны төрийн Монгол Улсын нийт төрийн албан хаагчдын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлдөг гэж түрүүн хэлсэн. Өнөөдрийн байдлаар ер нь бол яг төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн тоо бүртгэлийг тухайн оны 12 сарын 31-нээр тасалбар болгож бол тоогоо тавьдаг. Гэхдээ яг өнөөдрийн 10 сарын 1-ний байдлаар бол Монгол Улсад нийт 4271 төрийн байгууллагад 228820 төрийн албан хаагч ажиллаж байгаа. Энэ хүмүүсийн 1,7 хувь нь улс төрийн албан хаагч нар, 9,59 хувь буюу 10 хувь нь төрийн захиргааны албан хаагч, 20 хувь нь төрийн тусгай албан хаагч, үлдсэн 68 хувь нь төрийн үйлчилгээний албан хаагч байдаг.

Ерөнхийдөө бол төрийн албан хаагчдын дундаж нас сүүлийн 3 жил залуужиж байгаа. Яг бид нарын тоо бүртгэлд нэгдсэн дүнгээс харахад одоогийн байгаа төрийн албан хаагчдын дундаж нас бол 38,6. Тэгэхээр 2 жилийн өмнө бол 40 байсан юм байна лээ. Тэгээд одоо 38,6 гэдэг нь залуужиж байна. Гэхдээ залуужиж байгаа хэдий ч төрийн албаны тогтвор суурьшлын байдал бас жсоохон сэтгэл эмзэглүүштэй зүйлүүд бас тоо бүртгэлээс харагддаг. Яагаад гэхээр энэ улс төрийн, улс төр гэдэг нь бол яах вэ өөр байх. Төрийн тусгай, төрийн захиргаа, төрийн үйлчилгээнд ажиллаж

байгаа албан хаагчдын шилжилт хөдөлгөөн төрийн албанд орж байгаа, гарч байгаа байдал нь 1-ээс 5 жил дээрээ бүх түвшиндээ адилхан байгаа. Ер нь давамгай гэсэн үг.

2-т нь бол залуучуудыг төрийн албанд оруулахын төлөө ТАЗ бас нэлээн олон ажил зохион байгуулж байгаа. Энэний нэг нь юу вэ гэхээр анх төрийн албанд оръё гэсэн хүсэл эрмэлзэлтэй залуучуудад зориулсан төрийн албаны ерөнхий шалгалт гэж явдаг. Энийг жилд 1 удаа авдаг байсныг 2 болгоод, 2023 оноос эхлээд энийг 4 удаа авдаг болсон. Яагаад ингэж байгаа юм бэ гэхээр зөвхөн нэг жилийг хүн хүлээгээд суугаад байхаасаа илүүтэй шалгалтаа өгөөд нөөцөд бүртгэгдчих юм бол тэр хүний нөөцийн хугацааг нь 3 жил байхаар бас хуульд өөрчлөлт оруулсан. 3 жилийн хугацаанд тухайн хүн төрийн албанд орох боломжийг нь бид нар бас нээж өгч байгаа юм. Өнгөрсөн оны яг нөөцөд байгаа хүмүүсийн хөдөлгөөн бид нар энэ хүмүүсийнхээ хэдэн хувийг төрийн алба руу оруулаад байна гэхээр 40 хувийг бол оруулж байна. Яагаад ингээд 40 хувь байгаа юм бэ гэхээр төрийн доод шатнаасаа энэ хүмүүс маань төрийн албанд орох ёстой юм байгаа юм. Ерөнхий шалгалтын нөөцөд байгаа хүмүүс. Тусгай шалгалт нь бол өөр, хуульд заасны дагуу. Тэгээд бид нар бол энэ дээр ямар ч байсан Монгол Улсын төрийн албан хаагчдын хүний нөөцийн хөдөлгөөнийг нэлээн сайн эргэлтэд оруулах, залуу хүмүүсийг бол төрийн албанд мерит зарчмаар ажиллуулах тал дээр бол ТАЗ нэлээн дорвитой арга хэмжээнүүдийг бол зохион байгуулж байгаа.

Эд хогшил, урсгал засварын зардал гэдэг нь ТАЗ болон Ёс зүйн хороо хоёулаа түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг. Энэ эд хогшил гэдгээсээ илүүтэй энэ зардлын ангиллын гол дийлэнх нь төсөв юу түрээсийн зардал руу бас явж байгаа. Тэгээд бид нар Их Хурлын даргыг ирэхэд бас биеэ даасан байрны асуудал

хөндсөн. Урсгал засвар гэдэг нь бол байрандаа их, бага хэмжээгээр засвар хийх асуудал байна. Эд хогшилын хувьд бол энэ онд 2 байгууллагынхаа эд хөрөнгийн тооллогыг хийгээд, 5-аас дээш жил ашигласан зарим техник, тоног төхөөрөмж дээр бол бас тодорхой хэмжээний шинэчлэл хийх нь зүйтэй юм байна гэдгийг Төрийн өмчийн хороотой хамтарсан ажлын хэсэг гаргаад бас дүгнэлт гаргаад явж байгаа. Тэгэхдээ энэ нь учиргүй машин унаа ч юм уу тийм юм худалдаж авахгүй, яг төрийн албан хаагчдад хэрэгцээтэй байгаа зүйлсийг л авна гэсэн ийм төлөвлөлттэй байна. Энэ бол 2 байгууллагын юм явж байгаа. 3 аравны хэдэн тэрбумын асуудал ярьж байна. Энэ бол.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Гүйцээгээд хариулчих 3 номер.

**Л.Цэдэвсүрэн:** Энэ хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо гэдэг манай цахим систем байдаг. Монголын бүх төрийн албан хаагчдыг бүртгэж байдаг. Энэ цахим систем өөрөө 2022 оноос үйл ажиллагаа нь яг жигдрээд явж байгаа, 19 оноос эхэлсэн. Тэгээд энэ маань одоогийн байдлаар бол яг нөгөө дэд бүтэц нь маш хуучирчихсан, системийнх нь аюулгүй байдал нэлээн асуудалтай болчихсон байгаа юм байна лээ. Ноднин 2023 онд Тагнуулын ерөнхий газар болон холбогдох байгууллагуудтай ажлын хэсэг гаргаад энэ системийн аюулгүй байдал, нууцлалтын шалгалт хийлгэсэн. Тэгэхэд бол дэд бүтцийн болон ХУР систем дээр байгаа тэр нөгөө зарим яг мэргэжлийн хэллэгээр бол серверүүд дээр бол шинэчлэл хийх нь зүйтэй гэдэг ийм дүгнэлт гаргачихсан. Тэгэхээр энэний бол 6 сервер авахад бид нар 1,2 тэрбум, программ лиценз авахад бол 1 тэрбумын асуудлыг бол шийдье гэдгээр төлөвлөлтөө бол хийсэн байгаа.

**Б.Баярбаатар:** Хариулт болсон уу Очирбат гишүүн, тодруулах уу? Энхтуяа гишүүн асуулт асууна.

**Д.Энхтуяа:** Би нөгөө жоохон хоцорч орж ирсэн болохоор энэ асуулт давхардаад, тэгээд хариултыг нь сайн сонсож чадсангүй. Тэгэхдээ дахиад хариулт авчихъя. Энэ ТАЗ-ийн энэ багцын мэдээлэлд орж ирснээр энэ нөгөө урсгал зардал нь 2024 онтой харьцуулахад 189,6 хувь нэмэгдсэн байна л даа. Тэгээд цалин хөлсний бас урамшуулал нэлээн нэмэгдсэн байна. Тэгэхээр энэ 52,4 хувь нэмэгдсэн гэсэн ийм мэдээлэл ороод ирсэн. Тэгээд цалин бол одоогоор 2024 оныхоор 10 хувь нэмэгдсэн, 25 онд болохоор 6 хувь нэмэгдэнэ гэсэн. Ингээд нийт 16 хувь гэж ойлгоод байгаа юм. Тэгэхээр энэ урамшууллын зардал нь нэмэгдээд байгаа юм уу эсхүл ажлын байр нэмэгдсэн юм уу, яагаад энэ 52,4 хувиар ингээд нэмж орж ирсэн бэ гэсэн 1 дүгээр асуулт байна.

2-т нь энэ бас л түрүүний гишүүд бас ингээд юу яагаад байна, хөндөөд байна. Тэгээд хангамж материал 166,5 хувь, эд хогшил, урсгал зардал 828 хувь, томилолт зардал гээд л ингээд л, бусдаар хийж гүйцэтгүүлэх 419,5 хувь, бараа, үйлчилгээний зардал гээд л ингээд ер нь бол энэ 2024 оноос 6,5 дахин ингээд нэмэгдэж орж ирсэн ийм мэдээлэл бид нар дээр энэ задаргаа дээр байна л даа. Тэгээд энэ зардлын задаргаа байхгүй ерөнхий ийм том тоонууд ороод ирчихсэн байгаа юм. Тэгэхээр энэ ямар бүтцээр өөрчлөгдөөд байгаа юм уу, ажлын төлөвлөгөө байгаа юу? Энэ задаргаа нь энэ бас энэ улсын төсөв дээр бас байхгүй, ерөнхий том дүнгээрээ ингээд ороод ирчихсэн байна л даа. Тэгэхээр Байнгын хороон дээр бид нар бас нэгэнт ингээд асуудлыг нарийвчилж асууж байгаа учраас энэ задаргааг нь бид нарт өгөх боломжтой юу гэсэн ийм асуулт байна.

**Б.Баярбаатар:** 3 номер  
Цэдэвсүрэн дарга.

**Л.Цэдэвсүрэн:** Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Цалин хөлс нэмэгдэлтэй холбоотой асуудал нэмэгдсэн гээд. ТАЗ 56 ажлын алба нь 56, Ёс зүйн хороо ажлын алба нь 24, энэ дээр

Ёс зүйн хорооны 9 гишүүн, ТАЗ-ийн 5 гишүүн нэмэгдэнэ. Цалинг яагаад ингээд нэмчхэв гэхээр ажлаа авснаас хойш ТАЗ-ийн би ажлаа 24 оны 2 сард хүлээж авсан. Ажлаа авснаас хойш ТАЗ-ийн албан хаагчдын энэ албан тушаалын ангилал зэрэглэл, цалин хөлсний судалгааг хийлгэсэн юм. Тэгээд энэ ТАЗ өөрөө Улсын Их Хурлаас баталсан албан тушаалын ангилал зэрэглэлээр явдаг АА гэдэг. Ёс зүйн хороо маань бас адилхан АА. Тэгээд энэ хүмүүсийн цалин хөлсийг ингээд судлаад үзсэн чинь яамдын хэлтсийн дарга, яамдын ахлах шинжээч нараас цалин хөлс нь 30 гаруй хувиар бага. Тэгсэн мөртөө өөрсдөө төрийн албаны төв байгууллага буюу ТАЗ-ийн, Монгол Улсын ёс зүйн хорооны ажлын албаны ахлах референт, шинжээч гэсэн ийм албан тушаал дээр ажиллаж байсан. Хүний нөөцийн хөдөлгөөн маш их хийгдчихсэн. Сүүлийн 2 жил ерөөсөө хүн ороод л 3 сар болоод л гардаг, 2 сар болоод л гардаг нэг ийм байгууллага яг үнэндээ бол хүлээж авсан.

Ёс зүйн хороо маань бол шинэ байгууллага учраас энэ бол байгаагүй. Одоо шинээр хүмүүсээ ингээд авч байгаа юм. Тэгээд ЗГ болон Их Хурал, тухайн үедээ, тухайн үеийн Их Хурал, тухайн үеийн Байнгын хорооддоо асуудлаа тавиад, энэ хүмүүсийг яг ажлын албаны АА гэдэг ангилал зэрэглэл дээр нь цалинжуулъя. Яг үүгээр нь явахгүй бол энэ албан тушаалынх нь болон нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл нь бол үнэндээ хангалтгүй байна гэдгийг санал гаргаад, тэгээд цалин хөлс маань бол нэмэгдсэн. Манай хүмүүсийн албан хаагчдын цалин бол нэлээн нэмэгдсэн. Энэ маань ингээд 25 оны төсөв дээр нийт төрийн албан хаагчдын цалинг 6 хувь нэмнэ гэдэгтэйгээ уялдуулаад ингээд нэлээн өсөлттэй орж ирж байгаа гэдгийг бас гишүүд маань ойлгоорой гэж хүсэх гэсэн юм. Яагаад гэхээр бид нар төрийн албаны төв байгууллага, Ёс зүйн хороо гэдэг энэ 2 том байгууллага улсын хэмжээний үйл ажиллагаа явуулж байж тодорхой хэмжээний бас нэг цалин хөлс, нийгмийн



баталгааг нь хангасан байж тогтвор суурьшилтай ажиллуулахгүй бол хэтэрхий их хөдөлгөөн, хүний нөөцийн хөдөлгөөн хийгдээд байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд бас нэлээн сөрөг нөлөө үзүүлэх хандлагатай болчихсон байсан юм 1 дэх нь.

2 дахь нь бид нар энэ төсвөө хийхдээ ингээд задаргаа, төлөвлөлтүүдээ бүгдийг нь хийчихсэн байгаа гишүүнээ, танд хэрвээ хэрэгтэй гэвэл бид нар энэ нэг одоо байгаа бэлэн материалаа бол шууд өгч болно. Тодорхой хэмжээний үйл ажиллагааны зардлын талаар бас түрүүн хэлэхдээ өмнөх, өмнөх онуудын төсөв дээр ерөөсөө энэ ТАЗ-ийн төсвийн 68-аас 70 хувь нь цалин хөлс, нийгмийн баталгаандаа явчихдаг, 19 хувь нь нөгөө хүний нөөцийн удирдлага, мэдээллийн систем болон түүний хөгжүүлэлтдээ явчихдаг. Үлдсэн хувь нь л зөвхөн үйл ажиллагааны зардал байсан. Тэгээд бүх зардлуудаа дандаа энд тэндээс гуйдаг, нэг юм хийнэ тэрийг тэгчхээч гэдэг ийм байдлыг нь ер нь больё. Нэгэнт л Төрийн албаны хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд энэ 2 байгууллагын үйл ажиллагааны бүх төсвийг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж байгаа юм бол бид нар чиг үүргээ хэнээс ч хараат бус, чанартай, бодитой хэрэгжүүлэхийн тулд төсвөө яг бодитойгоор нь төлөвлөж, энэ 25 оны төсвийг бол хийе гэж 2 байгууллага зөвлөл болон хороогоороо хэлэлцээд, төсвөө ингэж төлөвлөсөн байгаа. Танд дэлгэрэнгүй мэдээллүүдийг нь өгье.

**Б.Баярбаатар:** Энхтуяа гишүүн тодруулга болсон уу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14 дэх хэсэгт зааснаар гишүүн зарчмын зөрүүтэй саналаа хэлэлцүүлэг явуулахаас өмнө ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлэхээр заасан. Манай Байнгын хорооны хамрах асуудлын хүрээнд Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал бол гараагүй. Тийм учраас

зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт бол явагдахгүй нь.

Ингээд төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хороонд хэн танилцуулах вэ? Энхтуяа гишүүн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/**

Дараагийн асуудалдаа орно. Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хийх ажлын төлөвлөгөөнд туссан 1.1-д Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.2, 7.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах санал боловсруулах, 1.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Ёс зүйн хороо, дэд хороодын бие даасан хараат бус байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах, 2.2.Зарим төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаатай танилцах, заасан ажлуудыг нэгтгэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж байгаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Ажлын хэсэг ТАЗ-ийн гишүүн, Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс, Ёс зүйн хорооны Ажлын



албаны дарга Н.Ганбаатар нар ирсэн байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Тогтоолын төслийг уншиж танилцуулна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан хараат бус ажиллах нөхцөлийг хангах эрх зүйн орчныг сайжруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Хүрэлбаатарын Баасанжаргал Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн гишүүд Ариунзаяа А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн, Д.Бум-Очир Улсын Их Хурлын гишүүн, Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын гишүүн, Д.Рэгдэл Улсын Их Хурлын гишүүн, Б.Хэрлэн Улсын Их Хурлын гишүүн, Д.Энхтуяа Улсын Их Хурлын гишүүн, Ц.Амартөгс Ёс зүйн хорооны дарга, ТАЗ-ийн гишүүн, Б.Пүрэвдагва Ёс зүйн хорооны гишүүн, ТАЗ-ийн гишүүн, Ш.Батсүх Ёс зүйн хорооны гишүүн, Удирдлагын академийн багш, А.Алтанзул Удирдлагын Академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, С.Бат-Орших МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Д.Наранцэцэг Ёс зүй, дэгийн Байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх, Н.Ганбаатар Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга, Б.Мажигсүрэн Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх, нарийн бичгийн даргаар О.Мөнгөнчавхдас Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны референт.

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах, эрх зүйн

орчныг сайжруулах саналыг 2025 оны 1 дүгээр сарын 15-ны дотор боловсруулж, Байнгын хороонд танилцуулахыг Ажлын хэсэг Х.Баасанжаргалд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төслийн агуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд нэрсээ. Лодойсамбуу. Лодойсамбуу гишүүнээр тасаллаа. Лодойсамбуу гишүүн асуулт.

**Ч.Лодойсамбуу:** Байнгын хороон даргаа ажлын хэсгээс гарах саналтай байна. Нөгөө хариуцсан ажлын хэсэг асар их байна.

**Б.Баярбаатар:** Өөрийн, бусад нөгөө Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж байгаа учраас амжихгүй гэж хэлж байна уу тийм ээ? Ойлголоо, саналыг хүлээж авлаа. Өөр асуулт байхгүй, асуулт асууж дууслаа. Санал хэлэх гишүүд байна уу? Алга санал хэлэх гишүүд алга байна.

Тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдээс 9 гишүүн зөвшөөрч, 69,2 хувиар санал, тогтоол батлагдлаа.

16.33 цаг

### **Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл**

Дараагийн асуудал байна. Байнгын хорооны тогтоолын тогтоолын төсөл батлах 3 дахь асуудал байгаа. Энэ ганцхан асуудал байгаа, одоохон дуусгачихъя. Энэ холбогдолтой асуудлыг манай Байнгын хорооны Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүн Ариунзаяа та бүхэнд танилцуулна. Агуулга утга учир нь юу вэ гэвэл Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны /МҮЭХ/ Ерөнхийлөгчийн албан тушаалыг давхар хашиж байсантай холбоотой асуудлаар

холбогдох иргэнээс гомдол ирсэн байгаа. Иргэнээс гомдол ирсэн учраас Байнгын хорооны дарга аль нэг Байнгын хорооны гишүүнд хариуцуулан холбогдох хуулийн дагуу тайлбар мэдээллийг ирүүлэх авхуулж, Байнгын хороонд танилцуулах ёстой. Ингээд миний бие Ариунзаяа гишүүнд тухайн тайлбар авах үүрэг даалгаврыг өгч, Ариунзаяа гишүүн Эрдэнэбат гишүүнтэй уулзаж, холбогдох тайлбарыг авсан. Энэ талаарх мэдээллээ та танилцуулна уу. Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны иргэн Э овогтой Золжаргалаас 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Ёс зүй, дэгийн Байнгын хороонд хандаж, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.15-д Улсын Их Хурлын гишүүн ТББ-ын хамтын шийдвэр гаргахаас бусад удирдах албан тушаал эрхлэхийг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байгаа талаар өргөдөл ирүүлсэн.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргаас Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Байнгын хорооны дарга хүлээн авч, Байнгын хорооны аль нэг гишүүнд хянуулахаар шилжүүлнэ гэж заасны дагуу Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн надад хянуулахаар хүргүүлсэн. Уг асуудлаар 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбаттай уулзаж, Улсын Их Хурлын гишүүний Ёс зүйн дүрэм 10 дугаар зүйлийн 10.4.1 дэх заалтын дагуу тайлбар авсан.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат нь тайлбартаа МҮЭ-ийн Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ 24 оны 7 дугаар сарын 1-ний өдөр ерөнхий зөвлөлдөө гаргасан. Хэдийгээр гаргасан боловчиг тухайн байгууллагын дүрмийн дагуу эвлэлийн их хурлаар шийдвэрлэгддэг тул

албан үүргийг дэд ерөнхийлөгчид хариуцуулахаар шийдвэрлэсэн. Жилд 2 хурал болох боломжгүй тул дараа жил буюу 25 онд Их хурлаа зарлана гэж шийдвэрлэсэн гэж тайлбар өгсөн.

Хэдийгээр дэд ерөнхийлөгчид түр энэ албан үүргийг хариуцуулах шийдвэр гарсан боловчиг олон нийтэд хандсан арга хэмжээнүүдэд С.Эрдэнэбат өөрөө Ерөнхийлөгч гэсэн статусын дагуу арга хэмжээнүүдэд оролцож, үйлдвэрчний эвлэлийг Ерөнхийлөгчийн хэлбэрээр төлөөлж явсан нь зөрчил үүсгэж байна гэж үзсэн учраас сануулах арга хэмжээ авах нь зүйтэй гэж гишүүнтэй ярилцаж, өөрөө бас сануулах арга хэмжээ авах энэ саналыг бас хүлээж авсан гэдгийг хэлмээр байна.

Тайлбарын хувьд гадаад руу бас Үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгчийн шугамаар явсан. Үүнд МҮЭ-ийн урилгаар давхар Монгол Солонгосын парламентын бүлгийн гишүүний хувиар Солонгос руу айлчилсан гэдэг ийм тайлбар өгсөн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр 10 сарын 7-нд болсон Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хорооны хуралд мөн Үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгчийн хувиар тус хуралд оролцсон нь тайлбар нь бол Хөдөлмөрийн 3 талт хэлэлцээрийн хувьд урьд хариуцаж байсны хувьд тайлбар өгч оролцсон гэсэн ийм тайлбарыг өгсөн байгаа юм.

Гэсэн хэдий ч түр хариуцах хүнийг томилсон л бол тэр хүн Ерөнхийлөгчийн түр албан үүргийг гүйцэтгэгч гэдгээр ажлаа хариуцаж, олон нийтэд ч гэсэн ийм байдлаар хандах ёстой учраас Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.13 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэж, Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 11.1.1-д заасны дагуу сануулах сахилгын хариуцлага Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатад тооцох нь зүйтэй гэсэн саналыг оруулж байна.

**Б.Баярбаатар:** Ариунзаяа гишүүнд баярлалаа. Саяын хийсэн танилцуулгатай холбоотой асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Би ингээд тогтоолын төсөл уншиж танилцуулна. Рэгдэл гуай, Рэгдэл гишүүн.

**Д.Рэгдэл:** Тэгэхээр Эрдэнэбат гишүүнийг бол МҮЭ-ийн байгууллагын даргын хувьд жагсаалтаар нэр дэвшүүлж, Их Хурлын гишүүнээр сонгосон. Тэгэхээр энэ хүн бол тэр ажлаа хашиж байж Их Хурлын гишүүний ажлаа хийвэл ул нь үр нөлөө сайтай болно. Яагаад вэ гэвэл МАН-ын дарга Оюун-Эрдэнэ Эрдэнэбат гишүүнтэй хамтран ажиллах МАН МҮЭ-ийн байгууллага хамтран ажиллах гэрээ байгуулж, гарын үсэг зурсан байгаа. Тэгэхээр энд нэлээн зөрчил харагдаад байгаа юм л даа. Үйлдвэрчний байгууллагын Ерөнхийлөгчийн хувьд жагсаалтад орж гишүүн болчихоод, гишүүн болонгуутаа больё, би гишүүнийхээ ажлыг хийе гээд явах бол ёс зүй талаасаа, би ёс зүй талаасаа гэж хэлье. Энэ жаахан онцгүй.

Зүгээр хуулийг яаж тайлбарлах вэ гэдэг асуудал нь зөвхөн Улсын Дээд шүүхэд байдаг болохоор тэндээс тайлбар авч байж бид нар энэ асуудлыг хэлэлцмээр байна гэж би санал оруулж байгаа. 2 дугаарт би Эрдэнэбат гишүүнтэй уулзаагүй болохоор сайн мэдэхгүй юм. Энэ түр орлон гүйцэтгэгч тавих шийдвэрийг ямар субъект гаргасан юм бол гэж л асуух гээд байна л даа. Өөрөө тушаал гаргачихсан юм биш байгаа гэж бодоод байхгүй юу дотроо. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Эрдэнэбат өргөдлөө Ерөнхий зөвлөлдөө гаргасан. Байгууллагынхаа дүрмийн дагуу ерөнхий зөвлөл нь ч гэсэн түр орлонгоо бас хариуцуулж шийдвэр гаргасан гэдэг ийм тайлбарыг өгсөн. Ёс зүйн асуудлын хувьд бол нэн ялангуяа Рэгдэл гуай та ч гэсэн яг адилхан Шинжлэх ухааны академийг

төлөөлж жагсаалтад орсон. Төлөөлнө гэдэг маань өөрөө дуу хоолой болж, тухайн байгууллагын дэвшүүлэх асуудал, тулгамдаж байгаа асуудлуудыг Улсын Их Хуралд дуу хоолой болно гэдэг нь өөрөө тухайн байгууллагын заавал Ерөнхийлөгч нь байх ёсгүй. Энэ бол тийм ёс зүйн алдаа биш гэж үзэж байна.

Тийм ч учраас та бол сонгогдонгуутаа бас Ерөнхийлөгчийнхөө ажлыг өгөөд, түр орлонг бас хариуцуулаад явж байгаа. Ийм учраас энэ асуудалд гүүр болж, дуу хоолой болно гэсэн болохоос биш тухайн байгууллагыг удирдаж, цалин хөлстэй, хөлсгүй удирдах албан тушаалд байж болохгүй гэдгийг Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хууль, Ёс зүйн тухай энэ дүрмээр ч гэсэн оруулчихсан, баталгаажихсан байгаа учраас үүнд Эрдэнэбатын хувьд иргэнээс гомдол ирсэн байгаа учраас үүнийг бид хэлэлцэж, үнэхээрийн тийм байна, энэ бол хэдийгээр өргөдлөө өгсөн ч гэсэн энэ үүргийг өөрөө түр орлон байхад өмнүүр нь орж Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгээд байгаа нь өөрөө ёс зүйн зөрчил юм. Ийм учраас сануулах арга хэмжээ өгч, өргөдлийг биелүүлэх, түр орлон бүрэн гүйцэд тухайн байгууллагыг төлөөлөх, Эрдэнэбат бол зүгээр дуу хоолой нь болох харилцаатай байх ийм үүрэгтэй шүү гэдгийг сануулах ийм арга хэмжээ авч байгаа юм.

**Б.Баярбаатар:** Рэгдэл гишүүн тодруулна.

**Д.Рэгдэл:** Ерөнхийдөө ойлгож байгаа би. Тэгэхдээ бид нар нэг эхлээд ямар ч арга хэмжээ авдаг байсан нэг хуулийн тайлбар авчихмаар байгаа юм. Дараа, дараа хэрэг болно. Дараа дараагийн ажилд хэрэг болно гэж үзээд.

**Б.Баярбаатар:** Ингэнэ. Ер нь бол энэ Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой асуудал Үндсэн хуулийн цэцэд их олноор очих болж байгаа. Тэгээд энэ бол цаад агуулгаараа бол Монгол Улсын парламентын дархлааны асуудал байгаа

юм. Энэ Эрдэнэбат гэдэг хүндээ биш, энэ Нарантуяа гэдэг хүндээ биш. Өнөөдөр бид нар энэ парламентад сууж байгаа тохиолдолд бас энэ Улсын Их Хурлын гишүүдийн мэдээж ингээд хуулийг бол бид нар тайлбарлах эрх байхгүй.

Тэгэхдээ өнөөдөр энэ хуулийг хэн яаж тайлбарлах вэ, хэн яаж ойлгож хэрэглэх вэ гэдэг асуудал өөрөө их чухал асуудал. Цэц дээр очоод ямар хэлбэрээр тайлбарлагдаад, ямар шийдвэр гараад ороод ирэхийг бид нар тааварлашгүй, тийм ээ. Жишээлбэл энэ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 44.1.15 дээр байна л даа. Энэ Улсын Их Хурлын гишүүн дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэсний доор ТББ-ын хамтын шийдвэр гаргахаас бусад удирдах албан тушаал эрхлэх гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр Үйлдвэрчний эвлэл бол яг энэ агуулгаар харах юм бол хамтын шийдвэр гаргадаг байгууллага 1-д, 2-т гэх юм бол тусдаа хуулиар зохицуулагддаг байгууллага. Тусдаа дүрэмтэй байгууллага.

Тэгэхдээ бид нар энэ болгоомжлолыг өнөөдөр бас авч үзэх ёстой. Дээр нь Ариунзаяа гишүүний хэлж байгаа энэ яг деталь зүйл рүүгээ ороод явах юм бол үйлдвэрчний эвлэлийн байгууллагыг төлөөлөд бас гадаад, дотоодын зарим арга хэмжээнд оролцсон нь өөрөө бол бас нийгэмд харагдах өнцгөөс бол яг Үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгчөөрөө давхар албан тушаал хашиж байна гэж харагдаж байгаа. Хашиж байна гэж харагдаж байгаа.

Тийм учраас энэ ёс зүйн хариуцлагыг ногдуулах нь бол зөв юм гэж ойлгож байгаа. Зөв юм гэж ойлгож байгаа. Рэгдэл гишүүний гаргасан саналыг бол бид нар энэ хуулийн тайлбарыг авна. Зүгээр бид нар яг ийм зүйл, заалтад хуулийн тайлбар авъя гээд Дээд шүүх рүү бичиг явуулахад, Дээд шүүх

бас нэг тийм яг хуучин бол ийм албан ёсны тайлбарыг ирүүлдэг байсан бол одоо бид нар ч бараг нэг тийм тайлбарлах эрхгүй ч юм шиг нэг тийм хариултыг ирүүлээд байдаг болчихсон байна лээ Дээд шүүх. Нэг ёсны бас болгоомжлол л байх л даа янз бүрийн байдлаар. Тэгээд тэр тусмаа хууль тогтоох байгууллагаас тайлбар ирүүлэхийг ингээд явуулахаар ингээд буцаагаад ирүүлж байгаа хариу нь тийм тодорхой бус хариулт ирүүлээд байгаа. Тэгээд дахиад бас энэ тал дээр бид нар бас анхааръя. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөл танилцуулна.

Ёс зүйн хариуцлага ноогдуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3.10, 22.3.13 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.5.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 105 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсгийг үндэслэн тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.13 дахь хэсгийг зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатад сануулга өгөх сахилгын хариуцлага ноогдуулсугай. Тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Тэгвэл тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт. Санал хураалт. 8 гишүүн зөвшөөрсөн санал өгч, 61,5 хувиар тогтоол батлагдлаа.

16.46 цаг

Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал үүгээр дуусаж байна. Хүрэлцэн ирж, оролцсон Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.





